







МЯЛ БОГД

ГЭМТНЭЭС ГЭГЭЭНТЭН





Printed and donated for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.
Tel:886-2-23951198, Fax:886-2-23913415
Email:overseas@budaedu.org
Website: <http://www.budaedu.org>
This book is for free distribution, it is not for sale.
ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО



«Мялын намтрыг уншихад насны нүгэл ариусдаг» гэж номт өтгөс, буянт буурлууд маань хуучилж ирсэн. Энэ намтрын эзэн бол хүн төрөлхтөний түүхэнд Будда Шагжамүни лугаа эн зэрэгцэх суу алдрын эзэн, төгс гэгээрсэн богд багш Мялрайва (1052- 1135) ажгуу.

Тэрээр баян айлын танхил хүү болон мэндэлж, алт мөнгөнд умбаж явсан ч удалгүй урвамтгай орчлонгийн хатуу тоглоомд өртөж, зовлонгийн ёроол унадаг. Хувь заяаны хуй салхинд туугдаж явсаар тэр хар нүглийн замд орно. Догшин хараалын хүчээр өш хонзонгоо авч, олон хүний амь амьдралыг бусниулдаг. Өшөө авалт нь түүнд баяр жаргал өгсөнгүй. «Өдөр хоол орохгүй, шөнө нойр хүрэхгүй, суухад явмаар санагдаж, явахад суумаар санагдаж» хийсэн нүгэлдээ шаналах болов. Ингээд тэр хар хорын хүлээснээс бүрмөсөн ангижрахыг хүсч, ариун номын эрэлд гардаг...

ЭНЭ ТҮҮХ 1052 ОНЫ
УСАН ЛУУ ЖИЛ БАЯН
ХУДАЛДААЧИН МЯЛ
ШАРАВЖАЛЦАНГИЙН
АМЬДАРЧ БАЙСАН
ХЯНГА-ЦА ГЭДЭГ
ГАЗАРТ ЭХЭЛЖЭЭ.



ТОЙВГОО ХҮҮГ (МЯЛ БОГД) 7 НАСТАЙД ААВ НЬ ХҮНДЭЭР ӨВДЖЭЭ...

БИ Ч ЭДГЭХЭЭСЭЭ ӨНГӨРЧЭЭ.
БУХ ӨВ ХӨРӨНГӨӨ ХҮҮГИЙНХЭЭ АВГА
АХ, ЭГЧ ХОЁРТ ШИЛЖҮҮЛЬЕ. ХҮҮГ
МААНЬ НАС БИЕД ХҮРЭХЭЭР ХӨРӨН-
ГИЙГ НЬ ӨГӨӨРЭЙ. МИНИЙ ХҮҮГ ХҮНИЙ
ГАР ХАРУУЛАЛГҮЙ ӨСГӨӨРЭЙ.

БИД БЭЛЭВСЭН ЭХНЭР,
ӨНЧИН ХҮҮХДҮҮДИЙГ
ЧИНЬ САЙН ХАРЖ
ХАНДАНА.
БҮҮ ЗОВ ОО.

ГЭВЧ АВГУУД АМЛАЛТАА МАРТАН БУХ ХӨРӨНГИЙГ
НЬ АВСАН ТУЛ ТЭД ЗУНДАА АВГА АХЫНДАА ӨВӨЛ
НЬ АВГА ЭГЧИЙНДЭЭ ЗАРАГДАХ БОЛЖЭЭ.





МЯЛ БОГДЫН ЭЭЖ ӨӨРИЙН БАГАХАН ТАЛБАЙДАА АЖИЛЛАЖ, ЖААХАН МӨНГӨ ОЛОХ ГЭЖ ХИЧЭЭНЭ.

ЭНЭ НАЙРАНД АВГА АХ, ЭГЧ БОЛОН ХӨРШ НАР НЬ ОРОЛЦОХ БАЙЛАА.



ТА БҮХЭН ТАЛИЙГААЧИЙН МААНЬ ГЭРЭЭСЛЭЛИЙГ САНАЖ БАЙГАА БИЗ. ХҮҮ МААНЬ НЭГЭНТ НАС БИЕД ХҮРСЭН УЧИР ХАДГАЛУУЛСАН ХӨРӨНГӨӨ АВЬЯ.

ТИЙМ ШҮҮ. ТҮҮНИЙ ЗӨВ.

АВГА АХ ЮУ ГЭЖ ХЭЛЭХИЙГ СОНСЪЁ.



ЮУН ГЭРЭЭСЛЭЛ! ТИЙМ ЮМ БАЙХГҮЙ. ЧИ НААД ӨНЧИН ХҮҮХДҮҮДЭЭ АВААД ЭНДЭЭС ЗАЙЛ.



ЭНЭ ЯВДЛААС ХОЙШ ТЭДНИЙ
АМЬДРАЛ БҮР ДОРДЛОО.



ХҮҮ МИНЬ, ЧИ ХАР ШИД СУРЧ
БИДНИЙГ ЗОВЛОНД УНАГАСАН
АВГА АХ, ЭГЧ ХОЁРООСОО ӨШӨӨ
АВАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.



ЭНЭ МОРЬ, ОЮУ ХОЁР ЧАМД ХЭРЭГ
БОЛНО. ХЭРВЭЭ ЧАМАЙГ ХАР ШИД
СУРАХГҮЙ ИРВЭЛ БИ ҮХНЭ.




МЯЛ ХЭДЭН НӨХДИЙНХӨӨ ХАМТ
ЭХИЙНХЭЭ ЗАХИАСЫГ БИЕЛҮҮЛЭХЭЭР
НУТГААСАА ЯВЛАА.



ХҮНДЭТ НОМЫН БАГШ
МИНЬ. БЭЛЭВСЭРЧ
ХОЦОРСОН ЭЭЖ МААНЬ
НАМАЙГ ХАР ШИД ДОМД
СУРГАХААР НААШ НЬ
ЯВУУЛАА.



ЧИ МИНИЙ
НАЙЗ ХҮЛҮНБА
ЁНДОНЖАМЦТАЙ УУЛЗ.
БУСДЫГ ҮХҮҮЛЭХ
ШИДИЙГ ТЭР ЧАМД
ЗААЖ ӨГНӨ.



ИНГЭЭД ЗАНРОНГИЙН ХӨНДИЙД АМЬДАРДАГ
ХҮЛҮНБА ДЭЭР МЯЛ ОЧЖЭЭ.




ХҮНДЭТ НОМЫН БАГШ
МИНЬ. ЮНДЭН ТОЖАЛ
ЛАМТАН НАМАЙГ ТАНЬ РҮҮ
ИЛГЭЭЛЭЭ.



БИ ЧАМД ЭНЭХҮҮ ЗААВРЫГ ӨГЬЕ. ИД
ШИДИЙН ЗАН ҮЙЛЭЭ СУРГУУЛИЛЖ БАЙХ
АГУЙ ӨӨРТӨӨ БЭЛД.

ХОЁР ДОЛОО ХОНОГИЙН ТУРШ ЗААВРЫГ
БЯСАЛГАСНЫ ДАРАА МЯЛ БОЛОН ТҮҮНИЙ
БАГШИД МУУ ХАР ШИДИЙН ТЭНГЭРҮҮД
ХАРАГДАЖ ЭХЛЭВ.



ХАР ШИД СУРСАН МЯЛ ӨШӨӨГӨӨ АВАХААР БУЦАЖ ИРЛЭЭ.



ЭНЭ ҮЕЭР ТҮҮНИЙ АВГА АХЫН УУГАН ХҮҮ ДӨРВӨН БАГАНАТ БАЙШИНДАА ХУРИМАА ХИЙЖ БАЙЛАА.







ТОСГОНЫ ИРГЭД МЯЛЫГ АЛАХААР ЯВСАН Ч ЭЭЖ НЬ ЭНЭ ТАЛААР ХЭДИЙНЭ МЭДСЭН БАЙВ.



МЯЛ ТОСГОН БҮХЭЛДЭЭ ХАРАГДАХААР
ГАЗАР ОЧИЖ, ДОГШИН ТЭНГЭРҮҮДИЙГ
ДУУДАЖ ЭХЛЭВ.



ТЭР ДОРОО МАШ ХҮЧТЭЙ МӨНДӨР БУУЖ
ТОСГОНЫ ТАРИАН ТАЛБАЙ СҮЙДЛЭЭ.



МЯЛ БОГДЫГ ИРЭХИЙН ӨМНӨХ ШӨНӨ МАРВА НАРОВА БАГШТАЙГАА УУЛЗАЖ БАЙНА ГЭЖ ЗҮҮДЭЛЖЭЭ. ТҮҮНИЙ ЗҮҮДЭНД:



АЖЛАА ДУУСГААД МАРВЫН БАЙШИНД
ОЧЛОО.

-ТА ЧИНЬ.

ЧИ НАМАЙГ ТАНИАГУЙ
БАЙЛГҮЙ. БИ ТЭР МАРВА
ЧИНЬ БАЙНА. ТИЙМЭЭС
ЧИ НАДАД МӨРГӨЖ
БОЛНО.

ХҮНДЭТ НОМЫН БАГШ МИНЬ, БИ БОЛ
НҮГЭЛТ ХҮМҮҮН. БИ ТАНД ӨӨРИЙН БИЕ,
СЭТГЭЛ БҮХНЭЭ ЗОРИУЛъя.

ЦАГ ХУГАЦАА УРСАН ӨНГӨРСӨӨР.
МАРВА БАГШ МЯЛД ТУН ХАТУУ
ХАНДАНА.

БИ ЧАМД АРАЙ Л ХАТУУ
ХАНДАЖ БАЙСАНДАА САНАА
ЗОВЖ БАЙНА. ХҮҮД МААНЬ
БАЙШИН БАРЬЖ ӨГ, БИ ЧАМД
ХААНА БАРИХЫГ НЬ ЗААЖ
ӨГЬЕ.

БИ ТАНЫ ХЭЛСНИЙГ
БИЕЛҮҮЛНЭЭ.



МЯЛ БАРИЛГАА БАРЬЖ ЭХЛЭЭД ЯГ
ДУНДАА ОРЖ БАЙТАЛ МАРВА ИРЛЭЭ.



БИ ЭНЭ ТАЛААР ӨМНӨ НЬ ЁСТОЙ
САНАСАНГУЙ. БАЙШИНГ НУРААГААД
НААД ЧУЛУУ БҮРИЙГ АВСАН
ГАЗАРТАА ЭРГҮҮЛЭЭД ТАВЬ.



ДАРААГИЙН ХЭДЭН САР МАРВА ТҮҮГЭЭР ӨӨР
ХОЁР Ч БАЙШИН БАРИУЛСАН БОЛОВЧ ЭРГҮҮЛЖ
НУРААЛГААД БАЙВ. МЯЛ БОГД ЧУЛУУ БҮРИЙГ
БУЦААЖ АВААЧИХДАА СЭТГЭЛ НЬ ҮНЭХЭЭР ИХ
ГОНСОЙНО.



НОМ ЗААЛГҮЙ БАЙШИН БАРИУЛЖ, БУУЛГУУЛСАН БАГШДАА ГОМДСОН МЯЛ НЭГ ӨДӨР
НОМЫН ОРДОНД НЬ ОРООД СУУЖЭЭ.



ТҮҮНИЙГ ҮХЭЭСЭЙ ГЭЖ ХҮССЭН МЯЛ БЭЭР
МАРВЫН ЭХНЭР ДЭЭР ОЧИВ.





ТҮҮНИЙГ СҮҮЛЧИЙНХЭЭ
БАЙШИНГ БАРЬЖ
ДУУСГАХААР БИ НОМОО
ЗААНА.


МАРВА НОМ ЗААДАГҮЙ ЭЭ... МЯЛ БОГД БАЙШИН
БАРЬЖ, БУУЛГАСААР... МЯЛЫГ ӨРӨВДСӨН МАРВЫН
ЭХНЭР НЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ ЗОХИОВ.



БАЙШИНГАА
БАРЬЖ ДУУСЛАА.
МАРВА
ОДОО НАДАД
ЭРДМЭЭСЭЭ ЗААЖ
ӨГӨХ БАЙГАА.



НӨХРИЙН МААНЬ ШАВЬ ДЭЭР ОЧ.
МАРВЫН ТАМГА, ЗУУЛТ ЧАМД ХЭРЭГ
БОЛНО.



МАРВАТАЙ САЛАХ ЁС Ч
ХИЙЛГҮЙГЭЭР МЯЛ ЯВЛАА.



МЯЛ БОГД ИЙНХҮҮ ТҮҮНД ТААЛАГДАЖ,
БЯСАЛГАЛ ХИЙЖ ЭХЭЛСЭН Ч...

ОЮУН САНААНЫ ДЭВШИЛ ОГТХОН Ч
ГАРСАНГУЙ. МЯЛ БОГД ҮНЭНЭЭ ХЭЛЭВ.

МАРВА НАДАД
ЗӨВШӨӨРӨЛ
ӨГӨӨГҮЙ. ХАРИН
ЭХНЭР НЬ НАДАД
ЭНЭ ЗАХИА БОЛОН
БЭЛГИЙГ ӨГСӨН
ЮМ.

НОМЫН БАГШИЙН
ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР
ОЮУН САНААНЫ
ДЭВШИЛД ХҮРНЭ ГЭЖ
НАЙДАЛТГҮЙ.


ТЭД МАРВА ДЭЭР ЭРГЭН ИРЛЭЭ.

АШГУЙ ЧИ НЭГ ЮМ ИРЭВ ҮҮ.

ХҮНДЭТ НОМЫН БАГШ
МИНЬ, БИ ЭНЭ ХҮНИЙГ ТАНЫ
МЭДЭЛД ӨГЪЕ.



ТЭР 10 ЖИЛИЙГ БЯСАЛГАЖ ӨНГӨРҮҮЛЖЭЭ. НЭГЭН ӨГЛӨӨ МЯЛ БОГД СОНИН ЗҮҮД ЗҮҮДЛЭВ.



МЯЛ ТӨРСӨН НУТАГТАА ЭРГЭН ИРЛЭЭ.

ТЭР ЮУН БАЙШИН БЭ. ЯМАР ХҮМҮҮС АМЬДАРДАГ ЮМ БОЛ?

ТЭР БОЛ ХАРААЛЧ МЯЛЫН БАЙШИН.
ТЭНД ХЭН Ч БАЙХГҮЙ ОЛОН ЖИЛ
БОЛЖ БАЙНА.




БУГД СҮЙРЧ НУРЖ УНАЖЭЭ.

ЭЭЖИЙН МИНЬ ЯС,
АРИУН СУДАР НЬ
БАЙНА.





ТЭР ХАЛГАЙГААР ХООЛМОЖ ОЛОН ЖИЛИЙГ ГАНЦААР ДАЯАНЧЛАН ӨНГӨРҮҮЛЭВ. МЯЛ ШАШИН АМЬТАНД ТУСЛАХ ХЭРЭГТЭЙ ГЭСЭН БУРХАДЫН ЗАРЛИГИЙГ ХҮЛЭЭН АВЧ БУСДАД СУРГААЛАА АЙЛДАХ БОЛОО.



ТҮҮНИЙГ ЗОРИН ИРЭГСЭДИЙН ДОТОР ОН УДААН ЖИЛ УУЛЗААГҮЙ ДҮҮ БИДА НЬ БАЙЛАА. ДҮҮ
НЬ ТҮҮНД ХООЛ ХҮНС АВЧИРЧЭЭ





БИЧИГТ ЗААСАН БЯСАЛГАЛЫГ ХИЙСНЭЭР СААД ТОТГОР
АРИЛЖ, АРИУН ҮЙЛС БҮТЭЭХ ГЭГЭЭРЛИЙН ЗАМ НЭЭГДЛЭЭ.

ҮҮНЭЭС ХОЙШ ОЛОН ЖИЛИЙН ДАРАА АВГА ЭГЧ НЬ МЯЛ ДЭЭР ИРЖ, ХИЙСЭН МУУ ҮЙЛЭЭ НАМАНЧИЛЖЭЭ.



МЯЛ ОЛНЫ ДУНД ИХЭД АЛДАРШЖЭЭ. ОЛОН ШАВЬТАЙ БОЛСНЫ ДОТОР ХАМГИЙН ИТГЭЛТЭЙ ШАВЬ НЬ РАЙЧҮН БАЙВ.



НЭГ УДАА НАЙРАНД УРИГДСАН МЯЛ БОГД ТЭР НУТГИЙН АЛДАРТАЙ ГЭВШ ЗАГНУВАГ МЭНДЛЭХЭД ХАРИУ ХЭЛСЭНГҮЙ.



ЭНЭ ХЭРМЭЛ БАДАРЧИНГ ХҮМҮҮС ЮУНД НАДААС ИЛҮҮ ХҮНДЛЭНЭ ВЭ. БИ ЧАМАЙГ ЗАМААСАА ЗАЙЛУУЛНА ДАА.




ЭНЭ ХОРТОЙ ТАРАГИЙГ МЯЛД ӨГВӨЛ БИ ЧАМАЙГ ТОМ ШАН ӨГНӨ ШҮҮ.



ТАРАГИЙГ ИДСЭН МЯЛД БОГД ХҮНДЭЭР
ӨВДӨВ.



БИ ИНГЭЖ ӨВДӨХ
УЧИРТАЙ БАЙСАН.



ГЭХДЭЭ БИ ЭНЭ ӨВЧНИЙГ
ШИЛЖҮҮЛНЭ. ТЭГЭХДЭЭ
НАДАД ӨГСӨН ХҮНД НЬ
ЭРГҮҮЛЭН ӨГӨХ БОЛНО.




ГАЙХАЛТАЙ ЮМ.
НАД РУУ
ШИЛЖҮҮЛЭЭЧ.




БИ ЭНЭ ХҮЧНИЙХЭЭ
БАГАХАН ХЭСГИЙГ
ЧАМД ХАРУУЛЪЯ.








МЯЛ БОГД РАЙЧҮНГИЙН ЗҮҮДЭНД ХАРАГДЖЭЭ. МЯЛ БОГД НАСАН ЭЦЭСЛЭЖ, ЗААВАЛ ЭРГЭН ТӨРНӨ ГЭЛЭЭ. РАЙЧҮНГ ИРСНИЙ ДАРАА Л ОРШУУЛГА БОЛЖ, ШАРИЛЫГ ЧАНДАРЛАЖЭЭ.



МЯЛ БОГД БЯСАЛГАЛ ХИЙЖ БАЙСАН БҮХ ГАЗАР ОРОНДОО НЬ НЭГЭН
ЗЭРЭГ ШАВЬ НАРТАА ХАРАГДЖЭЭ.





АРИУН ГЭГЭЭНИЙ ТУЙЛД ХҮРСЭН МЭРГЭДИЙН
ӨМНӨ МӨРГӨМҮ.

ХҮНИЙ АМЬДРАЛД ЮУ Ч ТОХИОЛДОЖ БОЛНО. ХҮН
ХЭЗЭЭ НЭГЭН ЦАГТ УУР ХОРСОЛДОО АВТАН ЯМАР Ч
МУУХАЙ ЗҮЙЛ ХИЙЖ МЭДНЭ. ХАРИН ТЭР БҮХНИЙГ
ЗАСАЖ ЗАЛРУУЛАХАД ОРОЙТОНО ГЭЖ ҮГҮЙ АЖЭЭ.
ҮҮНИЙ ТӨЛӨӨ МАШ ИХ ЗҮЙЛ ЗОЛИОСЛОХ Ч ХЭРЭГ
ГАРНА. ГЭВЧ УЧИРСАН СААД БЭРХШЭЭЛИЙН ӨМНӨ
УХАРЧ НЯЦАХГҮЙ, ӨӨРИЙН ЗОРЬСОНДОО ХҮРЭХ
ХЭРЭГТЭЙ АЖ. ЭНЭ ТУХАЙ ӨГҮҮЛСЭН МЯЛ БОГДЫН
НАМТРЫГ ЭМЭЭ МИНЬ НАДАД ЯРЬЖ ӨГДӨГ БАЙСАН
ЮМ.

ХАЙРТ ЭМЭЭ ЛУВСАНГИЙН ЦЭНДСҮРЭН
ТАНЬХАА МЯЛЫН НАМТАР ХҮҮРНЭН
БАЙСАН ГЭГЭЭН МӨЧИЙГ УЯРАН
САНАХЫН ЯЛДАМД ХОЙТЫН БУЯНД
ТАНЬ ЗОРИУЛАН АЧ ХҮҮ
Д.БАТБАЯР НЬ ГЭГЭЭН НОМЫН
МӨРӨӨР ЕРӨӨЛ ТАВИЛАА.

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.

May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA 南無阿彌陀佛

【蒙古文：密勒日巴尊者】

財團法人佛陀教育基金會 印贈
台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

This book is strictly for free distribution, it is not for sale.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

12,000 copies; March 2011

MO017-9295

